

НАМСРАЙ САХИУСНЫ МОНГОЛ НЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

С.Янжинсүрэн (Доктор Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим, ШУС. МУИС

Түлхүүр үг: Арван хангал, Намсрай сахиус, Сайтар сонсогчийн хөвгүүн, Вайшравана, Бисман тэнгэр.

Гол утга: Намсрай сахиус нь Бурханы шашинт ард түмнүүдийн дунд түгээмэл шүтэгддэг бөгөөд түүний нэр нь ихэнхдээ санскрит, төвдөөр нэрлэгддэг ба төвд нэрийн олон хувилбарыг монголчууд өөрийн хэлэндээ орчуулан судар бичигт үлдээсэн байна. Бусад нэрийн олон хувилбар байгааг эх сурвалж судруудад тулгуурлан шинжилгээ хийхийг оролдов.

Монголчууд 2000 гаруй жилийн тэртээгээс Бурханы шашны соёлтой нягт холбогдохдоо түүний бурхад, сахиусуудын ихэнхийг монгол хэлээрээ нэрлэж эх сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэн үлдээсэн боловч амьдрал, практикт санскрит, төвөд нэрээр нь нэрлэж хэвшсэн байна.

Бурхад, сахиусуудын монгол нэрийг бичгийн хэлэнд ялангуяа орчуулгын бүтээлүүдэд хэрэглэсэн нь элбэг бөгөөд ердийн хэрэгцээндээ төдийлөн түгээмэл хэрэглэж заншсангүй.

Монголчууд бурхад сахиусуудын нэрсийг санскрит, төвөд нэрээр нь нэрлэж тогтсон нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд:

1. Буддын соёл Энэтхэгт үүсч, түүний дэлгэрэлт хийгээд уламжилагдах үйл явцад нь Төвөд тэргүүлэх үүрэгтэй байсан учир ийнхүү бурхад сахиусуудын нэрийг энэтхэгийн хиндү, санскрит бас төвөд хэлний нэрийн дуудлагаар нь дорно дахинд хэрэглэж заншсан;
2. ХҮИ зуунаас монголчууд Төвөдтэй шашин соёлын харилцаагаа гүнзгийрүүлсэн нь монголд төвөд хэлт буддын утга зохиол хөгжих бат үндэс болсон бөгөөд буддын мэдлэг ухааны ойлголт, нэр томъёонууд болон төвөд үгс монголчуудын дунд төвөд

дуудлагаараа хэрэглэгдэж тогтсон;

3. Буддын соёлыг монгол соёлын нэг хэсэг болгон хөгжүүлсэн монголчуудын анхдагч академик гадаад хэл нь санскрит бичиг болон төвөд хэл байсан;
4. Бурханы шашны мэдлэг ухааны тал бүрийн сургалт, судалгаа монгол оронд төвөд хэл дээр онолын үндэстэй дэлгэрсэн зэрэг болно.

Бас тэрчилэн монгол хүнийг ч төвөд нэрээр нэрлэх явдал түгээмэл болж нэрийн утга учрыг сайтар мэдэхгүй, ойлгохгүй боловч сүсэг бишрэлдээ дулдуйдан хүүхэд багачуудынхаа ирээдүйн сайхныг бэлгэдсэн сайн утга агуулгатай нэрийг эцэг, эхчүүд нь үр хүүхэддээ лам багшаас хадаг барин гуйж авдаг ёс тогтсон бөгөөд өнөөдөр олон монгол хүн төвөд нэртэй байгаа нь үүн лүгээ холбоотой.

Ингэж төвөд дуудлагаараа монголчуудын дунд монгол нэр мэт хэрэглэгдэж заншсан төвөд нэр олон бөгөөд бурхад сахиусуудын нэр ч ихэнхдээ төвөд нэрээрээ хэрэглээнд нэвтэрсэн байна.

Төвөд нэрээрээ тийнхүү монголчуудын дунд танигдсан сахиусуудын нэг нь Намсрай юм.

Арван хангалын нэг, хойд зүгийг эрхшээгч хэмээгддэг Намсрай сахиусыг

бурханы шашинт улсууд түгээмэл шүтдэг ба тэрээр Бурханы шашин, бурханы шашинтныг хамгаалахаар ам тангараг авсан “Чойжин сахиус”-уудын нэг болно.



Зураг: 1

Намсрай сахиус нь нэг тэргүүн, хоёр мутартай бөгөөд алтан өнгөт биетэй, баруун мутартаа ялгуусны /ялалтын/ тэмдэг эрдэнийн дуаз, зүүн мутартаа элдэв эрдэнээр бөөлжсөн накула оготно¹ барьсан, хэвтэж буй арслан дээр хагас завилгаагаар заларсан /шүтээн зураг 1/ сүртэй сайхан дүртэй тухай Намсрай сахиусны цогчин уншлагын болон түүнд холбогдох зан үйлүүдийн бусад сударт дүрсэлсэн байдаг.

Гэхдээ энд хэлж байгаа нь түүний нийтлэг дүр бөгөөд өөр бас бус дүрүүд ч бий юм. Тухайлбал, арслан хөлөглөөгүй, босоо дүртэй Намсрай сахиусын шүтээн дүр нийтэд нэлээд түгсэн бөгөөд Улаанбаатар хот дахь Дашчойлин хийдийн мөргөлийн сүмийн ханын чимэг зурагт түүний босоо дүр /шүтээн зураг 2/ заларч бий юм.

¹ Үхэр оготныг санскритаар Накула гэх бөгөөд монгол бичгийн судруудад түүнийг нэүли хэмээсэн байдаг.



Зураг: 2

Намсрай сахиус нь бусад сахиусуудаас олон зүйлээр ялгарах ч түүний 2 нүд нь дүрлэгэр том бөгөөд эрс онцгой хурц харцтай бүтээсэн байдаг. Энэ талаар илт онох нэрсийн тайлбарт “Цэхэр нүдэт” /*Mig skya*/ хэмээсэн нь тэнгэрийн дагина Гоуригийн гоо үзэсгэлэнд машинд тачаан харсан тул түүний гэрэлд нүд нь улайж бүлчийсэнд анд нөхөр Ванчүг тэнгэр нь нүдний улааныг нь дарах гэж цайвар болгосон тул ийнхүү цэхэр нүдтэй болсон хэмээсэн нь бий².

Эндээс үзвэл Намсрайн 2 мэлмий тэнгэрийн үзэсгэлэнт дагинын биеэс цацрах гоо үзэсгэлэнгийн гэрэлд гялбаснаас ийнхүү өвөрмөц болсон гэж өгүүлсэн байна. Харин Ванчүг тэнгэр буюу Эрхэт тэнгэр нь Намсрайн ойрын нөхөр бөгөөд тэд харилцан бие биедээ тусалдаг болох нь дээрх ёгт нэрийн тайлбараас тодорхой байгааг холбогдох түүх, домгийг нь олж нягтлан судлууштай юм.

Намсрай сахиусыг монголчууд Баян Намсрай гэдэг. Энэ нь түүний эд баялгийг ивээн тэтгэдэг эрхлэн хариуцдаг үйлтэй нь холбон тодорхойлсон нь бөгөөд санскрит нэрээр нь Вайшравана /*Vaisravaṇa*/, төвөд нэрний товчоор нь Намсрай /*rNam sras*/, түүний бичлэгийн бүрэн дуудлагаар нь Намтойсрай /*rNam thos sras*/, тэдгээрийн монгол орчуулгаар нь Ариун сонсголтын хөвгүүн, *Тийн сонсголтын хөвүүн эсвэл Сайтар сонсголтын хөвгүүн* гэж тус тус нэрлэх ба нөхөр сэлтийнх нь тоогоор Найман

² Ngag dbang 'jigs grags, mNgon brjod kyi bstan bcos mkhas pa'i ma rgyan, Beijing, 1985.

Намсрай бас хятад нэрээр нь Бисман тэнгэр /Pi sha men/ ч гэж нэрлэнэ. Монгол нэрнээс бусад нь нийтийн хэрэглээнд түгээмэл хэрэглэгдэнэ.

Намсрай сахиус найман нөхрийн хамт залрахдаа 9 байдагч зөвхөн нөхдийнх нь тоогоор Найман Намсрай гэдэг онцлог бас бий.

Түүнээс гадна Намсрай сахиусны 25 зүйлийн ёгт нэрийг нэрлэж болох байна. Ёр нь юмсын ёгт нэрийг ихэнхдээ бичгийн хэлэнд, ингэхдээ утга зохиолд ашигладаг онцлогтой бөгөөд Намсрай сахиусын ёгт нэрс нь дараах байдалтай байна. Үүнд: 1.Хойд зүгийн эзэн /Byang phyogs bdag po/, 2.Хаадын хаан /rGyal po'i rgyal/, 3.Нууцын эзэн /gSang bdag/, 4.Цогт сан /dPal gter/, 5.Сангийн эзэн /gTer gyi bdag/ , 6.Цэхэр нүдэн /Migs skya/, 7.Хүмүүний номт /Mig ya mi'i chos ldan/, 8. Эдээр наадагч муу биет- /nor rtsen lus ngan/, 9.Алжаасныг амруулагч /ngal bsos po/, 10.Од-Янгийн ач-/'Od yangs tsha bo/, 11.Гурван үндэст /rTsa gsum pa/, 12.Гурван нүдэтийн найз /Mig gsum grogs po/, 13.Элагийн удам /E la'i rgyud/, 14.Эд өгөгчийг татагч /Nor sbyin 'dren pa/, 15.Ягчисын хаан /gNod sbyin rgyal/, 16.Өрөөсөн ээмэгт /rNa rgyan gcig pa/, 16.Эдийн эзэн /Nor gyi bdag/, 18.Эрдэнийн хур оруулагч /dByig gi char 'bebs/, 19.Орныг сахигч /gNas srung po/, 20.Их эрдэнийн зүрхэн /Rin chen snying po/, 21.Үргэлж амгаланг үйлдэгч /rTag bde byed/, 22.Гурван хөлт /rKang pa gsum ldan/, 23.Хүн унаат /Mi la zhon/, 24.Умар зүгийг тэтгэгч /Byang gi phyogs skyong/, 25.Сайтар сонсогчийн хөвүүн-/rNam sras/ болно.

Нэр бүр тус тусын домог түүхтэй ба ихэнх нэрийн утга нь тодорхой ч зарим содон нэрийн утгыг сийрүүлбэл:

1. Нууц сангуудын эзэн болохоор нь Нууцын эзэн /gSang bdag/
2. Тэнгэрийн дагина Гоури-ийн гоо үзэсгэлэнд машид тачаан үзсэний тул гэрэлд нүд нь улайж бүлчийсэнд нөхөр болох Ванчүгчэнбо тэнгэр бээр улааныг нь цайвар болгосон тул Цэхэр нүдэт /Mig skya/
3. Хүнтэй адил үйл хийдэг тул Хүмүүний

номт /Mi'i chos ldan/

4. Гурван хөлтэй, найман соёотой үзэшгүй муухай болохоор нь Муу биет³ /Lus ngan/
5. Өвөө нь тэнгэрийн арш Одын тул Одынгийн ач /'Od yangs tsha bo/
6. Гурван нүдэт буюу Ванчүгчэнбо-ын найз болох тул Гурван нүдтийн нөхөр /Mig gsum grogs po/
7. Одын аршийн хатан нь Эла бөгөөд түүний удам тул Элагийн удам /E la'i rgyud/
8. Түүний хэрэглэл нь хөлийн чинээ том бөгөөд хүнээр өргүүлж явдаг тул Хүн унаат /Mi la zhon/ хэмээн нэрийдсэн гэж илт онох нэрийн тайлбарт бичжээ⁴.

Монголчууд Намсрай сахиусыг түүний хятад нэрээр нь нэрлэх нь бас түгээмэл байжээ. Бисман тэнгэр буюу **Pi sha men** гэхийг монголчууд дуудлагы нь тэр хэвээр нь өөриймшүүлэн хэрэглэсэн бөгөөд энэ нь монгол, хятадын буддын соёлын харилцаа чамгүй ойр байсныг илэрхийлнэ.



Зураг: 3

³ Тус нэр нь Найман Намсрайн нэгэн нөхөр Кубера буюу Муу биетэд хамаатай. Түүний дүр байдал нь дээр дүрсэлсэн мэт байдаг ба Монгол Данжуурт ч энэ нэрээрээ орсон байна.

⁴ Мөн тэнд



Вайшравана хэмээх Намсрай сахиусны санскрит нэрийг хятадаар 毗沙门/Pi shamen/ хэмээн буулгасан бөгөөд түүнийг бүрнээр нь 大聖毗沙门天王 /*Da sheng Pi sha men tian wang*/ гэж нэрлэдэгийг монголчилбол Их сахиус Пишамэнь тэнгэрийн хаан гэж орчуулна. Хятад хэлэнд ч Намсрайг 毗沙门天 /*Pi sha men tian*/ *Пишамэнь тэнгэр гэж нэрлэдэг бөгөөд* Эндээс монголчуудын Бисман тэнгэр гэдэг нэр гарсан шиг байна.

Ингэж үзвэл нь монголчууд Бисман тэнгэр гэдэг эл нэрийг даруй хятад хэлнээс шууд зээлдэн хэрэглэсэн болох нь харагдаж байна.

Бас 乾陀山 /*gan tou shan*/ Ган тоу шань гэдэг хойт зүгт байдаг 2 уулын дунд 毗沙门-*Pi sha men* гэх нэртэй улс байсан тухай тайлбар ч бий юм. Энэ нь магадгүй хойд зүгт гэдэг угаараа Намсрай сахиус хойт зүгийг эрхшээдэг эсвэл хойт зүгт Сүмбэр уулын тэндэх Адагод оронд оршдог гэдэг домогтой холбосон байж болох бөгөөд цааш нарийвчилан судлуулжтай.

Эдгээрээс үзвэл монголчууд эд баялгийн эзэн Намсрай сахиусыг монгол, санскрит, төвөд, хятад нэрүүдийн аль алинаар түгээмэл сэлгэн нэрлэдэг болох нь

тодорхой байна.

Буддын шашны үзлээр Намсрай сахиус нь найман нөхрийн хамтаар хүмүүний амьдралын материаллаг ахуйн талыг хариуцах ба найман нөхөр бүгд морин унаатай тул Морины найман эзэн буюу Дадагжад /*гTag bdag brgyad*/ хэмээн нэрлэнэ. Дадагжад буюу Намсрай сахиусны 8 нөхөр нь: Замбала, Бүрнэбадра, Манибадра, Гүвэра, Самбазна, Гүхэдана, Банзига, Бизагүндали⁵ нар байна.

Намсрай сахиусны өвөг Кубера нь энэтхэгийн Хиндү шашны эд баялагийг эрхшээгч бурхан тэнгэр бөгөөд Хиндүизм нь дэлхийн хамгийн өндөр настай шашин соёлд ордгийн хувьд /МЭӨ 1500 оны орчим/ түүний өөрийн болон нөхөд сэлтсийн нэрс энэтхэгийн хэлүүдээр, тухайлбал хиндү, санскритаар өргөн тархсан байна. Энэтхэгийн нэгэн зүйл шашин Жайнизмд ч энэ Куберааг эд баялгийг ивээгч хэмээн түгээмэл шүтдэг.

Кубера буюу монгол бичгээр Гүвэра гэх энэ нэрийг монголчууд хэрэглэдэг боловч төдий л түгээмэл биш бөгөөд төвөд, монголын шашны уламжилалд Намсрай сахиусын нэгэн хор-нөхөр нь байдаг онцлогтой.

Гэсэн хэдий ч эл сахиусыг шүтдэг дорно дахины ард түмнүүд өөр өөрийнхөөрөө нэрлэж заншсан нь тодорхой. Гэхдээ Намсрай түүний нөхөд сэлтийн нэрсийг ийнхүүнэгэндорсанскрит, төвөд, монголоор нь олж бүртгэхэд амар байсангүй. Зарим сударт санскрит болон төвөд нэрийг холин хэрэглэсэн байх бөгөөд олж үзсэн төвд-монгол зарим сударт нэрсийг орчуулалгүй зөвхөн санскритаар нь хэрэглэсэн нь ч байна⁶. Бас тэрчилэн монгол Данжуурт Найман намсрайд холбогдох зохиолууд нөхөр тус бүрээр байгаа эсэхийг дахин шүүж үзэх хэрэгтэй байгаа юм. Ямартай ч олж цуглуулснаа хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

5 "rGyal bo chen bo, mam thos sras la, chod gtor 'bul ba 'Irim pa dngos grub kyi bang mdzod ces by aba bzhugs so" буюу "Ариун сонсолтын хөвүүн их хаан дор тахил балин өргөхийн зэрэг ишдэсийн хөмрөг сан нэрт оршиов" хэмээх 54 см х 9 см –ийн хэмжээтэй 26 цаас, нэг цасандаа 3 мөрөөр төвд-монгол хэлээр, төвөд цааснаа гараар бичсэн судар, 13а тал /Д.Хоролбатын хувийн номын сангаас зээлж хэрэглэв/

6 Мөн тэнд, *Их хаан Вайшраванд тахил балин өргөхийн зэрэг, ишдийн хүү сан хэмээхийг түшиглэн ихэнх бадаг үгсийг тэгшигтгэсэн хэмээгдэх оршиов. Мэргэн гэгээний сүнбүм, 3 дугаар боть, 1 дээд-25 дээд тал /хувийн номын сан/*

	Санскрит нэр	Монгол нэр	Төвөд нэр	Орших зүг	Биеийн өнгө Баруун	Гарын барьц		Уналга
						Зүүн		
	Вайшравана	1. Арнун сонсогчийн хүү 2. Тийн сонсогчийн хүү 3. Сайтар сонсогчийн хүү	Nam thos sras Nam sras	Хойд	Болгомол алтан	Эрдэнийн дуаз	Нэүли	Цагаан арслан
Намсрайн нөхөд сэлтэс Дадагжал								
1	Замбала	Хоргыг баригч ¹⁰	rMugs pa	Зүүн	Шар	Эрдэнэ	Нэүли	Шар морь
2	Бүрнэбадра	Дүүрэн сайт	gNgag ba bzang po	Өмнө	Шар	Хумх	Нэүли	Шар морь
3	Манибадра	Сайн эрдэнэ	Nor bu bzang bo	Баруун	Цагаан	Чандмань	Нэүли	Цагаан морь
4	Гүвэра	Их муу биет	Lus ngan	Хойд	Хар	Илд	Нэүли	Хар морь
5	Самбазна	Үнэхээр мэдэгч	Yang dag shes	Зүүн өмнө	Шар	Алтан хутга/ илд/	Нэүли	Шар морь
6	Гүхэдана	Хар хөдөөтөн	'Brog gnas nag po	Баруун өмнө	Хар	Улаан жад / эрдэнийн жад/	Нэүли	Хар морь
7	Банзига	Тав наадагч	lNga rtsen	Баруун хойд	Цайвар шар	Давхарлагаг байшин	Нэүли	Цайвар шар морь
8	Бизигүндали	Зөөлөн долгилсон ¹¹	'Jam po 'khyil ba	Зүүн хойд	Цагаан	Хутга, бамбай /илд, бамбай/	Нэүли	Цагаан морь

Намсрайн 8 нөхөр сэлт нь эд баялгийг ивээн тэтгэх ерөнхий үүрэгтэй ч тус тус, өөр өөр үйлийг хариуцдаг тул тэдний мутрын хэрэгтэн /хэрэгсэл/ болон тэдгээрийн дүр байдал, нэр сэлт нь өөр өөр байдаг. Харин бүгд морь унаж, оготно барьдаг нь тэдний дүрийн нийтлэг нь бөгөөд тэд өөр, өөр зүгт оршино гэж үздэг. Тэр хэрээрээ өөр өөр үйлийг эрхшээн хариуцна.

Тиймээс ч Намсрайн найман нөхрийг Найман морьтон гэхээс гадна тоогоор нь Найман Намсрай хэмээн нэрлэдэг байна.

Бас тэрчилэн Намсрай сахиус, түүний 8 хорыг Бүжигч дээд Бисман тэнгэр; Цагаан арслан хүлэгт Бисман тэнгэр; Хөх морьт Бисман тэнгэр⁷; Ногоовтор, шар бэрээт Бисман тэнгэр⁸ /Намсрайн аль нэг нөхөр мутартаа бэрээ барьсан байх тухай

бичсэн судар дор зурагт үзүүлснээс өөрийг одоогоор олж үзсэнгүй/; Догшин үйлдэгч Бисман тэнгэр; Улаан, жадат Бисман тэнгэр; Нас нэмэгдүүлэгч, цагаан Бисман тэнгэр⁹, Эрхин зарлигт Бисман тэнгэр зэргээр нэрлэдэг байсныг сударт тэмдэглэсэн нь дор эхийг хавсарган харуулав. Үүнд:

⁸ Унасан унаагаар нь нэрлэсэн байна.

⁸ Ногоовтор гэж лагшингийн өнгөөр нь, шар бэрээт гэж гарт барьсан хэрэгсэлээр нь нэрлэсэн бөгөөд судруудад Намсрайн аль нэг нөхөр бэрээ барьсан байх тухай заасныг үзсэнгүй.

⁹ Нас нэмэгдүүлэгч гэж түүний хариуцах үйлийг заасан байна.

¹⁰ Сумадираднагийн төвд-монгол дохионы бичигт Замбалагийн нэрийг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд, Замбха гэдэг нь rMugs pa буюу хорт, хортой гэсэн үг. Ла гэдэг нь барих гэсэн утгатай бөгөөд нийлээд хортыг баригч хэмээх утгатай гэжээ.

¹¹ Мөн дохионы бичигт үз.



Зураг: 5



Зураг: 6



Зураг: 7



Зураг: 8



Зураг: 8



Зураг: 10



Зураг: 11



Зураг: 12

Эндээс үзвэл монголчууд Намсрай сахиусыг эдийг хариуцагч, хойд зүгийг эрхшээгч хэмээх буддын шашин дахь түүний бэлгэдлийн ерөнхий утгаас нь гадна орчуулгын нэр болон домог түүхийн агуулга, гадна өнгө зүс, унаа хөлөг, гарын хэрэглэгдэхүүн, хүлээсэн үүрэг, хариуцсан үйл, тухайн сахиусны төлөв байдлаар нь ялган нэрлэдэг байсан нь тодорхой байна.

НОМ ЗҮЙ

1. *Тийн сонсогчийн хөвгүүний бүтээлийн арга*, Монгол Данжуур, 88 дугаар боть, 229 доод-230 доод тал
2. *Их муу биетийн бүтээлийн арга*, Монгол Данжуур, 88 дугаар боть, 230 доод-231 доод тал
3. *“rGyal bo chen bo, mam thos sras la ,chod gtor ‘bul ba’I rim pa dngos grub kyi bang mdzod ces by aba bzhugs so”* буюу *“Ариун сонсголтын хөвүүн их хаан дор тахил балин өргөхийн зэрэг шидэсийн хөмрөг сан нэрт оршив”* хэмээх 54 см х 9 см –ийн хэмжээтэй 26 цаас, нэг цасандаа 3 мөрөөр төвд-монгол хэлээр, төвөд цааснаа гараар бичсэн судар.
4. *“rGyal po chen po ngal bsos po’I sgrub thabs bsam ‘aphel dbang gi rgyal po shes bya ba”* буюу *“Их хаан Бисман тэнгэрийн бүтээлийн арга чандмань эрхтийн хаан оршвой”* хэмээх 54 см х 9 см –ийн хэмжээтэй 2 цаас, нэг цасандаа 3 мөрөөр төвд-монгол хэлээр, төвөд цааснаа гараар бичсэн судар / дээрх сударт хавсаргасан байв/
5. *Их хаан Вайшраванд тахил балин өргөхийн зэрэг, шидийн хүү сан хэмээхийг түшиглэн ихэнх бадаг үгсийг тэгшитгэсэн хэмээгдэх оршив. Мэргэн гэгээний сүнбүм, 3 дугаар боть, 1 дээд-25 дээд тал*
6. *Бисманы дорма өргөх ёсон хэмээх оршивой, 2 цаас, Мэргэн гэгээний сүнбүм, 3 дугаар боть.*
7. *rGyal chen mam sras bu khor bcas la gshegs gtor ‘bul tshul ‘adod dgu’i char ‘abebs shes bya ba bshugs so. /Сайтар сонсогчийн хөвүүн, нөхөд сэлтэд балин өргөх ёс, Хүслийн хурыг буулгагч хэмээх оршивой/ Бээжин барын төвөд судар*
8. Ngag dbang ‘jigs grads, mNgon brjod kyi

bstan bcos mkhas pa’I ma rgyan, Beijin., 1985.

9. Rene De Nebowsky-Wojkowicz, *Oracles and Demons of Tibet*. 1993.
10. *Ө.Сэрээтэр, Монголын их хүрээ Гандан хийдийн түүхэн бүтцийн товч, УБ., 1999.*
11. *Ш.Баясгалан, Арван хангал Бурхадын тахилга, УБ., 2010.*

A STUDY OF THE NAME “rNAM SRAS” (ABSTRACT)

Mongolia has a long and rich history with Buddhism, spanning a period of 2000 years from the early century to the present day.

Although Mongolians wrote Buddhist deities by Mongolian names in manuscripts and sutras, in daily lives and practices they were commonly referred to by their Sanskrit and Tibetan names.

Mongolian names of Buddhist deities can often be seen in literary translated works, but aren't commonly used in oral language.

Namsrai /in Mongolian pronunciation/ is best known to Mongolians as “Wealthy Namsrai” as the deity that brings wealth and riches. The Sanskrit name for Namsrai is “Vaisravana”, the Tibetan name is “rNam sras” /in written language/, the derivative of the proper written name “rNam thos sras”, The Mongolian name for the deity “Ariun songoltiin hovguun-The son of hearing purely” or “Tiin songoltiin hovuun, Saitar songoltiin hovguun- The son of hearing distinctly”. Also the Chinese name for Namsrai is “Bisman tenger-Pi Sha Men Tian Wang”.

All of these names apart from the Mongolian name of the deity are widely used in Buddhist literature, research and Buddhist communities.

In addition, Namsrai has 25 different allegorical names.